



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/88

Жаргалант

**Хагас жилийн эд хөрөнгийн тооллого
явуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн эд хөрөнгө болон төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 13-ний өдрөөс эхлэн ажлын 5 хоногийн хугацаанд явуулсугай.

2.Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга	Засаг даргын орлогч	Д.Шижирмөнх
Нарийн бичгийн дарга	Төрийн сангийн мэргэжилтэн	Б.Сумъяа
Гишүүдэд	Тамгын газрын дарга	Х.Баасансүрэн
	ЭМТ-ийн эрхлэгч	Г.Ариунзул
	ЕБС-ийн захирал	Х.Ууганцэцэг
	Цэцэрлэгийн эрхлэгч	Ө.Алтанзул
	Соёлын төвийн дарга	Н.Түмэндэмбэрэл

3.Эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолох, актлах эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, шинээр орж ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахыг гишүүдэд анхааруулсугай.

4.Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай явуулан дүнг нэгтгэж, гарсан зөрчил дутагдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай илтгэх хуудсыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ



Характеристики
Характеристики
Характеристики
Характеристики

В. Г. Гусев